


**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД НЭР ДЭВШИГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТҮР ЖУРАМ**



Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Гүйцэтгэх захиралд Монгол Улсын иргэн /цаашид “нэр дэвшигч гэх”/-ийг нээлттэй сонгон шалгаруулах ажиллагаа /цаашид “сонгон шалгаруулалт гэх”/-г энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.
- 1.3. Сонгон шалгаруулалт нь сонгон шалгаруулалтыг зарлах, нэр дэвшигчийн бичиг баримтыг хүлээн авах, дүгнэх үйл ажиллагаа болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтээс бүрдэнэ.
- 1.4. Төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулалт явуулах хугацааг товлон.
- 1.5. Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигчдэд тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэн тогтоож энэхүү түр журмыг хэрэгжүүлж ажиллана.
- 1.5. Нэр дэвшигчийн баримт бичгийн агуулга, нууцлалыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон Нэр дэвшүүлэх хороо хариуцна.
- 1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга сонгон шалгаруулалтад техник, зохион байгуулалтын тусалцаа үзүүлнэ.
- 1.7. Сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод байх, шударга ёсыг эрхэмлэх, хууль дээдлэх зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.
- 1.8. Нэр дэвшүүлэх хорооны гишүүн нь нэр дэвшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд бол тухайн нэр дэвшигчийг үнэлэх, хэлэлцэх ажиллагаанд оролцохгүй.


Хоёр. Сонгон шалгаруулалтын үнэлгээ

- 2.1. Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтыг баримтын бичгийн бүрдэл, нийтлэг болон тусгай шаардлагын үнэлгээ, ярилцлага гэсэн 3 үе шаттайгаар зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг 100 оноогоор үнэлнэ. Нэр дэвшигч нь энэхүү журамд заасан шаардлагыг хангасан эсэх байдлыг үнэлж дүгнэлт гаргана.
- 2.2. Сонгон шалгаруулалтад нэр дэвшигчийн 1 болон 2-р шатны нийлбэр үнэлгээ нь үнэлгээнд авбал зохих 100 онооны 60 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд 3-р шат буюу ярилцлагын шатанд оролцох эрхтэй болно.
 - 2.2.1. Сонгон шалгаруулалтын үнэлгээг Нэр дэвшүүлэх хорооны гишүүн тус бүр шат тус бүрийн үнэлгээний хуудсаар өгч нийт гишүүдийн дунжаар сонгон шалгаруулалтын оноог гаргана.
- 2.3 Нэр дэвшүүлэх хороо нь 3 шатны нийлбэр оноогоор хамгийн өндөр үнэлгээ авсан нэр дэвшигчийн баримт бичгийг дүгнэлтийн хамт Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлнэ.

2.4. Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын дүн, дүгнэлтийг 3 ажлын өдрийн дотор гаргаж, зөвхөн ярилцлагын шатанд тэнцсэн нэр дэвшигчдэд утсаар мэдэгдэнэ.

2.5. Нэр дэвшүүлэх хорооноос тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангасан Монгол Улсын иргэн уг сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй.

2.6. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны эрх хэрэгжүүлдэг нь давуу эрх эдлэх нөхцөл болохгүй.



Гурав. Бичиг баримтын бүрдэл болон нийтлэг, тусгай шаардлагын үнэлгээ

3.1. Бичиг баримтын бүрдлийг 20 хүртэл оноогоор

3.2. Нийтлэг болон тусгай шаардлагыг 50 хүртэл оноогоор

3.3. Ярилцлагын шатны үнэлгээг 30 хүртэл оноогоор:

Дөрөв. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

4.1. Сонгон шалгаруулалтын зарыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудас, компанийн цахим хуудас, компанийн албан ёсны социал хуудас болон өдөр тутмын хэвлэл зэрэг нийт 5-с доошгүй цахим болон хэвлэмэл хэрэгслээр 7-оос доошгүй хоногийн өмнө зарлана.

4.2. Сонгон шалгаруулалтын зард нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон нийтлэг, тусгай шаардлагын тухай, баримт бичгийг хүлээж авах газар, огноо, цаг хугацаа, албан тушаалтны нэр, хаяг, утас болон холбогдох бусад мэдээллийг тусгана.

4.5. Бүртгэлтэй холбоотой гомдлыг нэр дэвшигч сонгон шалгаруулалт эхлэхээс 3 хоногийн өмнө Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны даргад бичгээр гаргана.

4.5.1 Нэр дэвшүүлэх хорооны дарга гомдлыг үндэслэлтэй эсэхийг нягтлан шалгаж хариуг бичгээр 2 хоногийн өмнө өгнө.

4.6. Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичиг нь чанар байдлын хувьд үнэлэх боломжгүй, хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлсэн нь илэрсэн тохиолдолд баримт бичгийг үнэлэхгүй, нэр дэвшигчийг бүртгэлээс хасаж бүртгэлийг хүчингүйд тооцно.

4.7. Нэр дэвшигчийн хувийн мэдээлэл, материал, үнэлгээний мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хамгаална.

Тав. Нэр дэвшигчдэд хориглох зүйл

5.1. Нэр дэвшигчдэд дараах зүйлсийг хориглоно:

5.1.1. сонгон шалгаруулалтын хэвийн үйл ажиллагаанд саад учруулах;

5.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүдэд нөлөөлөх;

5.1.2. Баримт бичгүүдийг заасан хугацаанаас хожимдож ирүүлэх;

5.1.3. Ярилцлагын шатан тэнцэж, ярилцлагад оролцох хуваарьт цагаасаа хоцрох

5.1.5.сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалт зарласнаас эхлэн сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар эрх бүхий этгээдтэй биечлэн уулзах, утсаар ярих, цахимаар харилцах;

5.1.6. сонгон шалгаруулалтын үнэлгээнд урьдчилан нөлөөлөх гэсэн аливаа хууль бус оролдлого хийх.



Зургаа.Бусад

6.1. Энэхүү журмыг компанийн цахим хуудсанд байршуулна.

6.2. Энэхүү журам нь сонгон шалгаруулалтад нэр дэвшигч Гүйцэтгэх захирал томилогдсоноор үйлчлэх хугацаа дуусгавар болно.

.....ОоО.....